

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ХАРИУЦАН
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ
/12 арга хэмжээ/

2023 он

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
№	ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Хамтрагч	Төсөв (сая төгрөг)	Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)		Хэрэгжилтийн хувь
								2023 ОН		
								Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭР										
1	3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлэх, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх	1	1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлэх, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулна.	2020-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 38.826.8 2023 төсөв: 6,646.0 2023 гүйцэтгэл: 6,642.0	Нутаг дэвсгэрийн 46%-ийг хамруулах, ашигт малтмалын хэтийн төлөвтэй 20 талбай ялгана	1. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 10, 13-ны өдрийн /УТХ-2023-06 дугаар/ хуралдаанаар Асгат уул-50, Дэвийн хонгор уул-50, Түдэвтэй-50, Хулд-50 төслүүдийн үр дүнгийн тайланг хэлэлцүүлж давхарга зүйн 46 формац, гүний болон бага гүний 19 бүрдлийг ялган зурагласан. Ашигт малтмалын хувьд зэсийн 3, хар тугалга-цайр 1, марганец 1, лити 1, төмрийн 6, жонш 1, гантиг 1, өнгөлгөөний чулуу 3, элс, шавар, хайрганы 3, кварцын 1 нийт 21 илрэл, 144 эрдэсжсэн цэг, 134 геохимийн сарнилын хүрээ, 129 шлихийн сарнилын хүрээг тогтоож, мөнгө 3085 кг, зэс 216496 тн, цайр 23629 тн, сурьма 19500 тн, вольфрам 12500 тн, молибден 13800 тн, никель 8700 тн, хар тугалга 16996 тн, хүнцэл 647700 тн, төмөр 5825516 тн, мангани 53398 тн, өнгөлгөөний чулуу 30000 куб.м, шавар	100%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									4628000 сая. тонн таамаг нөөцийг тогтоож, Р зэргээр үнэлгээ өгч, хамгаалагдсан. Хүрсэн түвшин: Ингэснээр 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил Монгол орны нутаг дэвсгэрийн 45,15% хамрагдсан. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй 25 төслийн 2023 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, гаргасан дүгнэлтэд үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.19-ний өдрийн тушаалаар батлуулж, судалгааны ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Үүнээс 2023 онд үр дүнгийн суурин боловсруулалтын ажилтай Борзонгийн говь-50, Хар хайрхан-50, Овоот толгой-50, Үнэгт уул-50, Их хараат уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50, Улаангом-50, Их бэрхийн уул-50, Гилбэнт уул -50, Зангат-50 зэрэг нийт 13 төсөлд ҮГА-тай хамтран тайлангийн шуурхай хяналтыг хийсэн. 3. Цагаан-Овоо-50, Идэртийн нуруу-50, Загал уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Овоот шар-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Баян зүрх уул-50, Ханхар уул-50 төслүүд 2023 оны хээрийн үйлдвэрлэлийн ажил явагдаж байгаагаас эрлийн Загал уул-50, Бөөн хөх уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Баянзүрх уул-50, Ханхар уул-50 төслүүдэд шуурхай хяналт хийж, сар бүрийн ирүүлсэн гүйцэтгэлийг газар дээр нь баталгаажуулах, хэмжилт, хяналт хийж, мэргэжил аргазүйн зөвлөмжөөр ханган ажиллассан. Одоо Ямаат уул-50, Буйлс хүрэн уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50 шуурхай хяналт хийхээр бэлтгэж байна.	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 2023 оны эхний хагас жилд тогтоогдсон ашигт малтмал, ерөнхий эрлийн ажлын үр дүн урьдчилсан байдлаар дурдвал. Тайлан ирүүлсэн Загал-Уул-50, Уушгийн улаан-50, Үнэгт уул-50, Зангат-50, "Ханхар Уул-50, Их бэрх уул-50, Овоот толгой-50, Торлог Уул-50, Цэцэрлэг-50, Мөст уул-50, Баянзүрх уул-50, Борзонгийн говь-50, Индэртийн нуруу - 50, Цагаан Овоо-50, Үүрэг нуур-50, Гилбэнт Уул-50, Буйлст хүрэн уул-50, Хархайрхан-50, Овоот шар-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Их хараат уул-50 зэрэг нийт 22 төсөл ерөнхий эрлийн ажлаар дараах ашигт малтмалын судалгаагаар тогтоогдсон үр дүнг ирүүлсэн байна. Үүнд: 1. Бөгрөг уулын зэсийн илрэл, 2. Хороот уулын зэсийн илрэл, 3. Улаан толгойн зэсийн илрэл, 4. Урчуудын хөндийн алт-зэсийн илрэл, 5. Дэвсэнгийн алтны илрэл, 6. Улт улааны төмрийн илрэл, 7. Хөндлөнгийн бал чулууны илрэл, 8. Хөндлөн худгийн зэс-алтны илрэл, 9. Шавар худийн зэсийн илрэл, 10. Хүрэн бүстийн зэсийн илрэл, 11. Булагтын вольфрамын илрэл, 12. Цахир-Уулын алтны илрэл, 13. Баян-Өндөрийн алт-мышъякын илрэл, 14. Эхэн-Усны зэсийн илрэл, 15. Зүүн-Уужимын алт-мышъякын илрэл, 16. Цагаан толгойн алт-мышъякын илрэл, 17. Дунд-Уужимын мышъяк-сурьмагийн илрэл, 18. Мөргөцөг худгийн алт-мышъякын илрэл, 19. Бүлээн булгийн полиметаллын илрэл,	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									20. Хүрэн хадны алт-мышъякын илрэл, 21. Хөх нуурын шаврын илрэл , 22. Хяртын нуурын шаврын илрэл, 23. Баян уулын элсний илрэл, 24. Доод Нарийны голын алтны шороон илрэл, 25. Сүмбэр уулын бал чулууны илрэл, 26. Жалга нэртэй Манганы илрэл, Үүнээс гадна илрэл болох нь тогтоогдсон нэршил өгөгдөөгүй Алт-7, Алт-мышъяк-7, Зэс-7, Холимог металл-1, Манган-2ш, Мышъяк-3ш , Молибден-1, Висмут- 2, Гипс-2, Нүүрс-3, Үнэт эрдэнийн чулууны-2, Гоёлын чулууны 1 илрэл, Барилгын материалын түүхий эдийн 1 нийт 65 илрэлүүдийг тогтоогдсон бөгөөд Эрдэсэжсэн цэг 848, Цэгэн гажил 1093 лабораторийн шинжилгээний үр дүнгээр тогтоогдсон байна. - Гео-Орон ХХК-ийн хэрэгжүүлж байгаа Халзан овоо-50, Их цог өндөр ХХК хэрэгжүүлж байгаа Өндөр ширээт-50, Татах хүч ХХК-ийн хэрэгжүүлж байгаа Хайрхан овоо-50, Мадерланд ХХК-ийн хэрэгжүүлж байгаа Алаг баян-50 төсүүдэд холбогдох мэргэжилтнүүд тойрох хуудсаар хяналт хийж, ЭБМЗ-ийн хурлаар орж хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан. - Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын Хархайрхан-50, Их элээт уул-50, Цэцэрлэг-50, Их бэрх уул-50, Их хараат уул-50, Цагаан Овоо-50, Индэртийн нуруу -50, Загал-Уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Овоот шар-50, Үүрэг нуур-50, Мөст уу-50, Ямбат уул-50, Баянзүрх уул-50, Ханхар уул-50 төслүүдийн 2023 оны 3 дугаар улирлын тайланг хүлээн авч нэгтгэн, УУХҮЯ-нд	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									2023.10.26-ны өдрийн 2/583 тоот албан бичгээр илгээсэн.	
		2	1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0,15-ийг хамруулна.	2022-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 17,500.0 2023 төсөв: 6,000.0	Нутаг дэвсгэрийн 0.1%-д судалгааны ажлыг гүйцэтгэнэ.	Улсын төсвийн хөрөнгөөр 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг 2024-2028 онуудад Хархорин-25, Майдар-25, Чойбалсан-25, Налайх-25 төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний төсөлд санал боловсруулсан. Хүрсэн түвшин: Төслийг батлуулах ажил явж байна.	70%
		3	Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100%-ийг	2021-2023	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 3,515.2 2023 төсөв: 456.3 2023 гүйцэтгэл: 456.3	L, M /N/ хавтгай буюу нутаг дэвсгэрийн 100%ийг бүрхэх, үр дүнг хүлээн авна..	“1. Монгол орны нутаг дэвсгэрийн M хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:50000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх ажлын 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны A/21 дүгээр тушаалаар батлуулан ажлыг эхлүүлсэн. 2. Төслийн 2023 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж, ЭБМЗ-ийн 2023.02.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталгаажуулсан. ЭБМЗөвлөлийн дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын шийдвэрийн төслийг боловсруулан ажиллаж байна. 3. Монгол орны нутаг дэвсгэрийн L хавтгайн хэмжээнд улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх төсөл Монголын геологийн зургийн редакцын зөвлөлөөр хянагдаж, шүүмжлэгч томилуулах хүсэлтийг ЭБМЗ-д гарган ажиллаж байна. Монгол орны нутаг дэвсгэрийн L болон M хавтгайн хэмжээнд хээрийн судалгааны ажлыг бүрэн дуусгаж, эцсийн үр дүнгийн тайлан боловсруулалтын ажил хийгдэж, Монголын геологийн зургийн редакцын зөвлөлөөр хянагдаж, шүүмжлэгч томилуулах хүсэлтийг ЭБМЗ-д гаргаж ажиллав.	100%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
		4	Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70%-ийг	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 5,406.1 2023 төсөв: 88.7 2023 гүйцэтгэл: 88.7	Ховд-2020 төслийн үр дүнг хүлээн авах, нутаг дэвсгэрийн 66.6%-ийг хамруулах, Хангай-1 төслийг эхлүүлнэ	Ховд-2020 1:200000-ны масштабын агаарын геофизикийн судалгааны ажил -Нийлбэр соронзон орны эрчимжилтийн зураг, -Туйлын засвар хийсэн нийлбэр соронзон орны зураг, -Нийлбэр цацраг идэвхжилийн зураг (Tcnt), -Газрын калийн агуулгын зураг (K), -Газрын тори-ийн агуулгын зураг (Th), -Газрын ураны агуулгын зураг (U), нийт 6 төрлийн зураг 104044 кв.км талбайн хэмжээнд тайлбар бичгийн хамт зохиогдож, Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хангагдсан. Төслийн нийт гүйцэтгэл 99%-тай хэрэгжиж байна. 2. Монгол орны нутаг дэвсгэрийн 172693 кв.км талбайг хамрах Хангай-1 төслийг шинээр хэрэгжүүлэхээр холбогдох тооцоо судалгааны ажлыг гүйцэтгэсэн. “Геосан” ХХК-ийн гүйцэтгэж буй 1:200000 масштабын агаарын геофизикийн судалгаа “Ховд-2020” төслийн соронзон, уран, тори, кали болон 5 сувгийн нийлбэрийн зураг зохиодож, шинжээчийн дүнэлт гарсан. Хүрсэн түвшин: тайланд хяналтын хуудсаар холбогдох мэргэжилтнүүд хяналт хийсэн. Хүрсэн түвшин: ЭБМЗ-ийн хурлаар орж хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	90%
		5	Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн	2021-2022	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 1,258.1 2023 төсөв: -	Нутаг дэвсгэрийн 100%-д Геохими-2019 төслийг	Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1149529 км ² талбайн хэмжээнд 64 элементийн зураг зохиогдож, тайлбар бичиг боловсруулагдсан, Улсын геологийн зургийн редакцийн зөвлөлийн гишүүд дараах зургуудад редакц хийж байна. Үүнд: Гол 7 ислүүдийн зургууд болон Газрын ховор 14 элементүүдийн	90%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
			100%-ийг хамруулна.					үргэлжүүлэх ,	зургууд - Д.Оролмаа, Геохимийн сарнимал элементүүдийн зургуудыг Г. Дэжидмаа, Геохимийн эвшлийн 11 зургуудыг О.Мөнхцэцэг, О.Гэрэл, Г.Дэжидмаа, Газрын ховор элементүүдийн зургийг О.Гэрэл, Халькофиль-сидерофиль-литофиль элементүүдийн тархалтын зургийг О.Мөнхцэцэг, Эрлийн геохимийн үр дүнгийн зургууд А. Готовсүрэн нар гүйцэтгэж байна.	
		6	Бүс нутаг болон геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийнэ.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 7,708.8 2023 төсөв: 539.4 2023 гүйцэтгэл: 539.4	Дархан хотын судалгааны үр дүнг хүлээн авах, Чойбалсан, Ховд, Даланзадгад хот, Хангайн халуун рашаан геотермийн судалгааг үргэлжлүүлэх, Шаргалжуут геотермийн судалгааг эхэлнэ	“Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа” төсөл: Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа "ЭР геоэкологи-2019" төсөл ЭБМЗ-ийн 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн /УТХ-2023-06 дугаар/ хуралдаанаар хэлэлцүүлэгдсэн. Төслийн үр дүнгийн тайланг Монгол Улсын геологийн мэдээллийн санд хүлээн авах шийдвэр, дүгнэлт гарсан. "ЭР геоэкологи-2019" төсөл нь 1945.03 км ² талбайн хэмжээнд 1:25000-ны масштабын 23 хавтгайд: -хөрсний 2107, -гадаргын болон газрын доорх усны 419, -цасны 21, агаарын 66 (NO2, SO2 РМ 2.5, РМ10), -агшин зуурын тоосны 286, -цагаан тоос, орчны цацраг идэвхийн 1299, орчны дуу чимээний 31 хэмжилтийг стандартын дагуу гүйцэтгэж, үр дүнгийн боловсруулалт хийсэн. -Баримт материалын зураг, геоэкологийн зураг, гидрогеологийн зургийг тус бүр 1:25000-ны масштабаар 23 хавтгайд, -геоэкологийн суурь үнэлгээний зургийг 1:50000-ны масштабаар 10 хавтгайд, -геоморфологи, ландшафт,	90%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									-хөрсний зургийг 1:25000-ны масштабаар тус тус зохиож, өгөгдлийн сангийн тоон системд оруулсан. Хүрсэн түвшин: Төслийн талбайн хэмжээнд геоэкологийн судалгааны үр дүнг нэгтгэж, цаашид геологи орчинд нөлөөлөх агаар, хөрс, газрын доорх болон гадаргын усны ашиглалт, хамгаалалтын талаар дүгнэлт зөвлөмж өгсөн. “Дархан хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа” төсөл: Төсөл 2020-2023 онд хэрэгжиж байгаа бөгөөд хээрийн ажил дуусч үр дүнгийн тайлан боловсруулалтын ажил хийгдэж байна. Дархан геоэкологи төсөл нь 2605,7 км² талбайд 31 хавтгайг хамарна. Төсөл хэрэгжих хугацаанд -1923ш хөрс, -1110ш ус, -69ш цас, -63ш агаар тоосны сорьц ба хэмжилтийн ажлууд хийгдсэн. Бусад хэмжилт нэмэлт ажлын үр дүнд боловсруулалт хийгдэж байна. Төслийн хүрээнд: -Геологийн зураг 1:50000-ны масштабтай 9 хавтгай, таних тэмдгийн хамт, -геоморфлогийн зураг 1:50000-ны масштабтай 9 хавтгай, таних тэмдгийн хамт, -геоэкологийн төрөлжүүлэлтийн зураг 1:25000-ны масштабтай 31 хавтгай, таних тэмдгийн хамт, -гидрогеологийн зураг масштаб 1:25000-ны масштабтай 31 хавтгай, таних тэмдгийн хамт хийгдсэн. Дархан геоэкологийн төслийн үр дүнгийн тайлан Улсын геологийн зургийн редакцийн	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									зөвлөлийн гишүүдээр зургууд хянагдаж байна. Ховд хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа Ховд геоэкологи-2021 төсөл: Төсөл 2021-2023 онд хэрэгжиж байгаа бөгөөд хээрийн ажил дуусч боловсруулалтын ажил хийгдэж байна. Нийтдээ 1978 км² талбайд 23 хавтгайг хамарна. <u>Геоэкологийн судалгаа:</u> 1:25000-ны масштабтай геоэкологийн зураг зохиох мэдээ, баримтыг бүрдүүлсэн. Геоэкологийн чиглэлээр хөрс 1405 ш, ус 288 ш, цас 30 ш дээж авагдсан. Агаарын чанарын хэмжилт 45 цэгт, -агшин зуурын тоосны хэмжилт 200 цэгт, -дуу чимээний хэмжилт 50 цэгт, -орчны цацраг идэвхийн хэмжилт 900 цэгт, - чулуулгийн геохимийн сорьцлолт 10 сорьц, цацрагжилтын сорьцлолт /хөрснөөс/ 50 сорьцыг тус тус хийсэн. <u>Геоэкологийн зураг.</u> Судалгааны талбайн 1:25000 масштабтай нийт 23 листийн суурь зураг болох -геоморфологи, -ландшафт бүхий зураг лист тус бүрээр бэлтгэн, тоон системд оруулсан. Үр дүн: Хөрс, агаар, цагаан тоос, газар доорх болон гадаргын усны геохимийн үр дүн тус бүрээр боловсруулалт хийгдсэн. <u>Гидрогеологийн зураг:</u> Геологийн 1:50000-ны зургийг суурь болгон ашиглаж гидрогеологийн зургийг 1:25000 масштабтайгаар 23 хавтгайн хэмжээнд хийгдэж байна. Монгол орны төв болон хойд хэсгийг хамрах 602,984.0 км² талбайд гүний	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									хагарал, түүнтэй холбоотой рашаан булгийн судалгааны Гүний хагарал-1 төсөл: <u>Гүний хагарлын судалгаа</u>ны ажлаар төслийн талбайд Монгол орны тектоникийн муж, бүсүүдийг зааглагч гол структуруудыг ялган, мөрдөн шалгах, зураглах, зүсэлт хийх, ажиглалт хийх ажлууд хийгдсэн. Төслийн талбайн хэмжээнд өмнө ялгасан хувирмал цөм бүрдэлүүд (Бүтээлийн нуруу, Эрэндаваа, Хадаасан)-ийн хэмжээнд маршрутын судалгаа хийж холбогдох дээжлэлт хийгдсэн. <u>Идэвхтэй хагарлын судалгаа</u>ны чиглэлээр нийт 160 орчим идэвхтэй болон идэвхтэй байж болзошгүй гэж үзсэн хагарал түүний сегментүүдийг шалгаж, зураглах, мөрдөх ажлыг хийж гүйцэтгэсэн. <u>Палеосейсмологийн судалгааны</u> ажлаар хагарлын маршрутын судалгаа, морфологи-структурын судалгаа хийж гүйцэтгэсэн Моностой, Авдар, Хаг нуур хагарлууд болон Идэр, Эрхэл нуур, Хужирт, Тоом гол, Хогоргын хагарлуудад суваг малталтын ажлыг хагарлын бүсд -хөндлөн байдлаар ухаж, -палеосейсмологийн бичиглэл хийж, -булшлагдсан хөрснөөс радиокарбоны аргаар 49 дээж, элсэрхэг хурдсаас хэт улаан туяаны люминесценцийн судалгааны аргаар нас тогтоох 24 дээжийг авсан. Сорьцыг Оксфордын их сургуулийн лабароторид илгээгээд байна. <u>Морфологи структурын судалгааг</u> дээр дурдсан палеосейсмологийн судалгаа явуулж буй 8 хагарал болон Булнай, Баян-Агт, Эрчим, Цэцэрлэг, Дүнгэнээ, Таацын гол, Эгийн даваа, Өмнөд хангай зэрэг хагарлуудад 1-2 талбайд	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									Дроны зураглалын ажлыг нийт 96 км² талбайд хийж гүйцэтгэсэн. <u>Геотермийн судалгааны</u> ажлын хүрээнд дөрөвдөгчийн вулканоген чулуулаг тархсан талбайнуулыг бэлтгэл ажлын хүрээнд ялгаж, Өгий нуур, Орхон, Тариат, Өгөөмөр-Богд, Урантогоо гэсэн 5 районд буюу зураглалын маршрутын судалгаа хийж, голомт, урсацын талбай, үе давхаргуудыг ялган, фенокристалл(mega-crystal) бүхий урсац, үе давхаргаас сорьцлолтын ажил хийж гүйцэтгэсэн. <u>Гидрогеологи, рашаан бүлгийн судалгаа:</u> Нийт 192 орчим рашаан, булаг, эрдэст нуурт хүрч 186 рашаанд хэмжилт, бичиглэл, дээжлэлт, гидрогеологийн маршрутын судалгааны ажил хийж гүйцэтгэсэн. Рашааны хийн шинжилгээг газар дээр нь багажаар хэмжиж үзэхээс гадна титрлэх аргачлалаар нүүрст устөрөгч зэрэг дэгдэмхий хий агуулгыг газар дээр нь судалсан болно. <u>Геоэкологийн судалгаа:</u> Хульж, Гурван нуур, Аврага тосон, Ар жанчивлан, Цагаандэв, Өвөржанчивлан рашаан, Хужирт, Могойт, Их Шаргалжуут, Өхэг, Хүрэмт, Хануй, Галт, Зарт, Отгонтэнгэр, Хульж, Шивэрт, Цэнхэр, Хөнжил рашаан болон рашаан түшиглэн үйл ажиллагаа явуулж буй амралт сувилалын газруудын үйл ажиллагааны өнөөгийн байдалд геоэкологийн ажиглалт, хөрсний геохимийн дээжлэлт, гидрохимийн сорьцлолт, хэмжилтийн ажлыг хийсэн. <u>Гидрогеотермийн судалгаа:</u> Хужирт, Их Шаргалжуут, Отгонтэнгэр, Цэнхэр, Хульж, Хөнжил халуун рашаануудад гидрогеотермийн судалгаа хийсэн. Сонгосон талбайн хэмжээнд геологи, гидрогеологийн 1:50000, 1:25000-ны кондицийн бус зургийг	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									зохиохоор геологи, гидрогеологийн маршрутын судалгааг нарийвчилсан торлолоор хийж гүйцэтгэсэн. Хагарлын гар зургийг хянаж, хувирал, хагарлын чулуулгийг нэмж тэмдэглэх, fault plane solution бодуулж хагарлууд дээр тэмдэглэх, хагарлын насны интервалыг гарган тэмдэглэх, хагарлаар үүссэн структуруудыг тэмдэглэх, хагарлын төрлийг хянаж, тэмдэглэгээ гүйцээх, хам эвшил бүхий процессуудаар үүссэн структурыг тэмдэглэх, ARCGIS-д оруулах,Dbf бөглөх), хээрийн судалгааны ажлын үед цуглуулсан баримт материалыг нэгтгэх, ангилах, холбогдох дээжүүдийг анхдагч боловсруулалт хийж лабораторийн шинжилгээнд өгөх, баримт материалын зураг зохиох, хээрийн хэмжилтийн үр дүн зэрэг мэдээллийг цуглуулж нэгтгэн боловсруулалт хийхэд бэлтгэх компьютерт шивж оруулах зэрэг анхдагч боловсруулалтын ажлуудыг голчлон хийж гүйцэтгэхээс гадна судалгааны ажлын үндсэн үр дүнгийн зураг болох, хагарлын зураг, рашаан булгийн тархалтын байршлын зургийг эцэслэн боловсруулах, геофизикийн судалгааны үр дүнг боловсруулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Монгол Улсын босоо тэнхлэгийн бүсэд 2022-2024 онд хэрэгжүүлэх гео-орчин төсөл: Төслийн талбай нь Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Төв, Говьсүмбэр, Дорноговь зэрэг аймгуудын нутгийн, нийт 41 сумын нутаг дэвсгэрийн 52659.0 кв.км талбайг хамарна. 2023 онд хээрийн ажил хийгдэнэ.	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									<u>Геоэкологи, геоморфологи, гео-орчин судалгаа:</u> Бэлтгэл ажлын хүрээнд сансрын зурагт урьдчилан тайлсан гео-орчны зургийг газар дээр шалган баталгаажуулах зорилгоор маршрутын судалгааг 11 хавтгайн хэмжээнд 4203 т.км маршрутын ажил хийж 1554 цэгт ажиглалт бичиглэл хийсэн. <u>Техноген объект дахь геоэкологийн судалгаа:</u> 11 объект бүхий нийт 234 кв.км талбайд хийж, Айрагийн уурхай, Айраг сум, Даланжаргалан сум, Шивээговь сум, Баянтал сум зэрэг 7 объектын 28 кв.км талбайд дроны зураглалын ажил хийж, боловсруулалтын ажил хийгдсэн <u>Гидрогеологийн судалгаа:</u> Нийт 130 ажиглалтын цэгт анхдагч судалгаа, бичлэгийг хийсэн. Гидрохимийн задлан шинжилгээнд зориулж 124 ширхэг усны дээж авч, 4 худагт богино хугацааны сорилын шавхалт хийж, худгийн ундарга, ус агуулагч чулуулгийн шүүрэлтийн итгэлцүүрийг тодорхойлсон. Нийт 10 булгийн ундаргыг хээрийн судалгааны явцад хөвүүрийн аргаар тодорхойлсон. <u>Гидрологийн судалгаа:</u> Улаанбаатар хотоос хойш Төв, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгийн нутгуудад хийж 96 ажиглалт хэмжилтийн ажил, үүнээс усны чанарын хээрийн хэмжилт 84, гидрометрийн 67 хэмжилтийг хийгдсэн. Хээрийн судалгаагаар гол, нуур, цэвэрлэх байгууламжийн 84 дээж авсан. Гео-орчин төслийн 2023 оны хээрийн үйлдвэрлэлийн явцад шуурхай хяналтыг 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 08 дугаар сарын 02-ны өдрүүдэд гүйцэтгэсэн. Гео-орчин, геоморфологи, гео-экологи, түгээмэл тархацтай ашигт малтмалын эрлийн маршрутын судалгааны ажил гүйцэтгэж	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									хөрсний геохимийн сорьцлолт, маршрутын судалгааны ажлыг 2 бригадаар 1092 т.км маршрут хийсэн. Гео-орчин, геоморфологи, гео-экологи, түгээмэл тархацтай ашигт малтмалын эрлийн маршрутын судалгааны ажил гүйцэтгэж хөрсний геохимийн сорьцлолт, маршрутын судалгааны ажлыг 2 бригадаар 1092 т.км маршрут хийсэн. Гео-экологийн судалгаа (Техноген объект дахь) - ны ажлыг Багануур дүүрэг, Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн, Жавхлант, Дулаанхаан, Баянгол, Мандал, Сайхан, Хөтөлийн уурхай, Номгон сум, Баянчандмань, Борнуур зэрэг сумдууд, Түнхэл тосгон, Багануурын уурхай, Хөтөлийн уурхай орчим гэсэн 14 объект бүхий нийт 253 кв.км талбайд хийж гүйцэтгэлээ. Цацрагийн хэмжилтийн ажлыг Багануур, Баруун бүрэн, Жавхлант, Дулаанхаан, Баянгол, Мандал, Хөтөл, Сайхан зэрэг техноген объектод хийж гүйцэтгэв. Хүрсэн түвшин: 258 ажиглалтын цэгт гидрогеологи, гидрологийн болон сайрын хэмжилт, судалгаа хийж баримт материалын зурагт буулган ажилласан.	
		7	Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн хэтийн төлөвийн хэсэгчилсэн судалгааны ажил хийнэ.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 18,000.0 2023 төсөв: 5,036.8 2023 гүйцэтгэл: 5,036.8	Тек-2021, ТЗ-2021 төслийг үргэлжүүлэх, энергийн түүхий эдийн төлөв /ЭТЭ-2022/ төслийг эхлүүлнэ.	Баруун Монголын зарим бүсийн тектоник ба шатах ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа төсөл 2022 оноос эхлэн хэрэгжсэн. Судалгааны талбайн байршил: Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтайн зарим хэсэг 97,244,83 кв.км талбайд хавтгайн номенклатур М-46-А, Б, В, Г; L-46-А-Б /хэсэгчлэн/ БМШАМ-2022 кодтой төслийн ажил үргэлжлэн хэрэгжиж байна. Тухайн бүс нутагт тектоник тогтоцйн талаар судалгааны ажил хийгдээгүй, үүнийг дагалдан шатах ашигт малтмалын судалгааны ажлыг давхар гүйцэтгэхээр төлөвлөн хэрэгжүүлж байна.	70%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									Шуурхай хяналтыг 2023.07.19-26 -ны хооронд хийж гүйцэтгэсэн.	
		8	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 6,500.0 2023 төсөв: 227.9 2023 гүйцэтгэл 225.8	ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шатны ажлыг үргэлжүүлэх, бусад орнуудтай харилцан үр ашигтай төсөл эхлүүлнэ.	"Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процес ба металлогени" төслийн ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шатны ажлаар Монгол орны нутаг дэвсгэрт Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь аймгуудын нутаг дэвсгэрт байрших Алтайн нурууны үргэлжлэлийг хамарсан 1_47-ХІХ, ХХ, ХХІ, ХХІІ, ХХV, ХХVІ, ХХVІІ, ХХVІІІ, ХХІХ, ХХХ, ХХХІІІ, ХХХІV, ХХХV, ХХХVІ, ^-48-ХХV, ХХХІ хавтгайнуудын хэмжээнд 1:500000-ны масштабтай геологи, тектоник, геоэкологи, металлогений зургийг тайлбар бичвэрийн хамт зохиох төслийн ажлын хүрээнд : - Бүх талбайг хамарсан геохимийн болон геофизикийн мэдээллийг нэгтгэж байгаа бөгөөд геохимийн судалгаанд хамрагдаагүй байгаа зарим талбайнуудад нэмэлт хээрийн судалгаа явуулж экологи-геологийн судалгааны цөм болсон мэдээллийг бүрдүүлэх хээрийн судалгааны ажлыг 2021,2022 онуудад хийж төлөвлөсөн 300 дээжийг, суурь судалгааны дээжлэлттэй нэгтгэн Хятад –Монголын хилийн дагуу хийгдсэн геохимийн судалгааны явцад боловсруулагдсан аргачлалаар боловсруулан дуусч байна. - Говь Алтайн уулсын геологийн зураг, таних тэмдэгийн хамт /М 1:500 000; L-47-B/ 55 хувь гүйцэтгэлтэй, Зохиогчийн хувилбараар. Говь Алтайн уулсын геологийн зураг, таних тэмдэгийн хамт /М 1:500 000; L-47-Г/ 95 хувь гүйцэтгэлтэй, Зохиогчийн хувилбараар. Говь Алтайн уулсын геологийн зураг, таних тэмдэгийн хамт /М 1:500 000; L-48-B / 95 хувь гүйцэтгэлтэй, Зохиогчийн хувилбараар. Говь	70%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
							60,000, 000 вон буюу 160,000, 000 төгрөг	БНСУ-н KIGAM-тай хамтын ажиллагаан ы хүрээнд	Алтайн уулсын геозкологийн зураг, таних тэмдэгийн хамт /М 1:500 000; L-47-B/ 98 хувь гүйцэтгэлтэй, Зохиогчийн хувилбараар. Говь Алтайн уулсын геозкологийн зураг, таних тэмдэгийн хамт /М 1:500 000; L-47-Г / 98 хувь гүйцэтгэлтэй, Зохиогчийн хувилбараар. Говь Алтайн уулсын геозкологийн зураг, таних тэмдэгийн хамт /М 1:500 000; L-48-B / 98 хувь гүйцэтгэлтэй, Зохиогчийн хувилбараар. Говь Алтайн уулсын геодинамикийн зураг, таних тэмдэгийн хамт /М 1:1 000 000/ 98 хувь гүйцэтгэлтэй, Зохиогчийн хувилбараар. Алтайн уулсын структурийн дүүрэгчлэлийн нэгдсэн тойм зураг (М1:2 000 000, 2018-2023 оны талбайд) боловсруулан тоон санд 100 % эцэслэн засварласан. ОХУ болон БНХАУ-н геологийн албадын хийсэн судалгааны ажлын үр дүнг нэгтгэн боловсруулахад боломжтой байдлаар хийж байна. Геологийн даалгаварт тусгагдсан гүний трансект татах асуудал хийгдээгүй. - Хаг талбайд хамтарсан судалгаа, боловсруулалт хийх “КИГАМ” төслөөр: 1. Талбайн хэмжээнд танилцах маршрутыг өмнөх жилийн ажлаар илрүүлсэн хэт суурилаг биет, түүнтэй холбоотой ашигт малтмалын илэрц, сонирхолтой цэг болон янз бүрийн хувирлуудтай танилцах, тодорхойлох, хэлбэр, хэмжээг тогтоох зорилгоор 10 т.км гүйцэтгэсэн. 2. Эрлийн маршрутыг хүдэржилт бүхий биет, хувирлыг бүсийг нарийвчилан тогтоох, хил зааг тодорхойлох, шалган холбох маршрутыг чулуулгийн уяалдаа холбоо, хил зааг тодорхойлох зорилготойгоор гүйцэтгэсэн ба нийт 10 т.км маршрут хийв.	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									3. Зураглалын ажлаар нарийвчилсан талбайд чулуулгийн хил зааг тогтоох, талбайн техтоник структур болон литологийн өөрчлөлт бүрийн нарийвчилан тодорхойлох, 1:5000 масштабтай зураг зохиох зорилгоор 10 өдөр гүйцэтгэсэн. 4. Маршрутын явцад илрэх хувирал, хүдэржилтийн түвшинг тогтоох, хувирлын бүсүүдийг үнэлэх зорилгоор 80ш цэглэн сорьц авав. 5. Тоон шинжилгээг ашигт малтмалын төрөл, чулуулгийн онцлог зэргээс хамааруулан ICP-MS –н 30 элементийн багцад оруулан шинжлүүлэх ба одоогоор бүх дээж шинжилгээнд өгсөн. 6. Төслийн хээрийн судалгааны талбайд танилцах, эрлийн, шалган холбох, зураглалын маршрут хийх зорилгоор 6600 т.км тээвэрлэлт гүйцэтгэв.	
2	3.2.4.Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.	9	Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 2,000.0 2023 төсөв: 1,018.9 2023 гүйцэтгэл: 967.0	Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан хөтөлбөрийн төрөлжсөн мэдээллийн сан төслийг үргэлжлүүлэх, ажлын явц 60%	Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн санг Илрэл-3538, Худаг-4575, Цооног-5217, Шлихийн хүрээ-2705, Өрөмдсөн цооног-400, Эрдэсжсэн цэг-155 нийт 5880 ширхэг мэдээллээр баяжуулсан. Давхарга зүйн сан-707, Горизонт-61, Интрузив чулуулгийн сан-3362, Эффузив чулуулгийн сан-360, Палеонтологийн олдворын дэд сан-3567, Үнэмлэхүй насны сан-1119, 314 метадата оруулсан. Хүрсэн түвшин: Нийт 9400 мэдээллээр баяжуулсан.	100%
		10	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх,	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 6,000.0	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг	Ордын чулуун дээжийн мэдээлэл оруулах ажлын хүрээнд 250 ордын дээж бүртгээд байна. Чулуун дээжийн фото зураг авах ажлын хүрээнд дээжийн-3243 фото зураг авч 2950 дээжийн зураг засварлаж бичвэр	100%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
			баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.				2023 төсөв: 1,060.2 2023 гүйцэтгэл: 1,060.2	бүрдүүлэх, баяжуулах, бүрдүүлэх төслийг үргэлжлүүлэх, ажлын явц 60%	мэдээлэл оруулаад байна. Шлифийн 7544 ширхэг зураг ,аншлифийн 1301 ширхэг зураг, тайлангийн хавсралт материалаас 6166 лабораторийн үр дүнгийн хариуг сканер хийн оруулсан. Геологийн төрөл бүрийн тайлан цахимжуулах ажлын хүрээнд 519 тайлан, боть-1261ширхэг буюу 144930 хуудас, 12378 ширхэг хавсралт зураг цахимжуулсан. Цахим архивыг баяжуулах ажлын хүрээнд eDOC архивын программд 608 тайлангийн 1006 хадгаламжийн нэгж, 743 ширхэг цаасан суурьт баримт цахимжуулсан. Хүрсэн түвшин: 1006 хадгаламжийн нэгжийг нүүр, гарчиг, агуулгын түвшинд хайх ОЛС-ийн программд холбоход бэлтгэн ашиглалтын хувь үүсгэсэн.	
3	3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө	11	Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 5,686.1 2023 төсөв: 2,419.1 2023 гүйцэтгэл: 2,419.1	ГАСАМ төслийн үр дүнгийн тайланг хүлээн авах, ГХЭ-ийн хэтийн төлөвийн судалгааг эхэлнэ.	1. “Геологийн судалгаа шинжилгээний төв”-ийн хэрэгжүүлж буй Өндөр технологийн түүхий эд-I төслийн Нарийвчилсан эрлийн ажлаар Хатуугийн голын илрэлийн хувьд ЗХ чиглэлтэй ГХЭ болон Nb, Zr-ны сулавтар хүдэржилт бүхий аляскит маягийн боржингын сунаж тогтсон 150-350 м өргөнтэй биет нь судалгаагаар хамгийн өндөр утга нь ГХЭ-0,13%, Nb-0,05%, Zr-0,17%, Y-0,08%, дундаж утга нь ГХЭ-0,03%, Nb-0,01%, Zr-0,02%, Y-0,007%, байна. 2. Судалгаагаар эрэл-үнэлгээний ажил гүйцэтгэсэн Ихэрийн илрэлийн хувьд өмнөх судлаачид хэмжээ бага, хүдэржилттэй гол хэсгийг тогтоож чадаагүй, Nb-ийн илрэлийн хувьд тэмдэглэсэн хүдэржилт нь баруун талдаа буюу тунамал хурдасдаа илүү тогтвортой, өөрчлөлтгүй үргэлжлэж байгааг тогтоосон. Мөн талбайн зүүн хагаст дэл, судлын биетийг нарийвчилан зурагласан эрлийн Ихэрийн илрэлийн хувьд өргөрөгийн	100%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
	оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.								дагуу сунаж тогтсон 2-3 км хүртэл үргэлжилсэн 2-3 ш дэл, судлын биет шинжилгээгээр ГХЭ 0,03-1,3%, ихэнх дээжид Zr-0,5%-оос их, Nb 0,05-0,5% зэрэг агуулгатайгаар гадаргадаа илэрдэг. Дэл, судлын биет тус бүр агуулга нь харилцан адилгүй уул-өрөмдлөгийн ажил голлож хийгдсэн 1-р биетэд илүү өндөр агуулгатай тогтоогддог. Эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. 3. Демон инженеринг” ХХК-ийн хэрэгжүүлж буй Өндөр технологийн түүхий эд-II Төслийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 104 уртрагаас баруун зүгт хамраарах талбайд 2023 оны хээрийн судалгааны ажлыг 3 багийн бүрэлдэхүүнтэйгээр 4-р сараас эхлүүлэн төлөвлөсөн судалгааны талбайн хэмжээнд төсөлд тусгагдсан арга аргачлалын дагуу Өмнөговь, Дундговь, Дорноговь, Төв, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт ажиллаж байна. Түүнчлэн нарийвчилсан талбайн хэмжээнд ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн үнэлгээ өгөх зорилгоор ГХЭ-ийн Хар толгод, Жоншит, Баянхошуу зэрэг нарийвчилсан эрлийн хэсгүүдэд 435.20 м3 уулын малталтын ажилаас гадна 1800 т/м өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэв. - 2023 оны тайлант хугацааны хээрийн ажлаар Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутагт орших Мушгиа худаг ГХЭ-ийн ордын орчимд 5 талбай /Хар шарын даваа, Жоншит, Бор толгой/, Баянхошууны хэсэг, Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт никелийн	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									чиглэлээр Баргилт овооны хэсэг, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт лити-бериллийн чиглэлээр Баян-Уул, Арван сар, Дундговийн бүсийн хяналт-шалгалтын 1, 2 ба 3 зэрэг талбайнуудын хүрээнд хэтийн төлөв өндөртэй бал чулууны хэд хэдэн талбайг ялгаж хээрийн ажлыг гүйцэтгэлээ. Ажлын үр дүнг доор хэтийн төлөв бүхий талбай тус бүрээр аль болох дэлгэрэнгүй хэлбэрээр, одоогоор хэтийн төлөв нь тодорхой бус талбай болон бусад илрэл, эрдэсжсэн цэгүүд гэсэн ангиллаар бичиглэл хийлээ. Үүнд: ГХЭ-ийн хувьд Тушги худгийн нарийвчилсан талбайд 4 талбай ялган 1000 т/м өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэж Баянхошууны илрэл -0,-1,6% /ГХЭ/, Жоншит илрэл /ГХЭ/, Хар шарын давааны илрэл /ГХЭ/, Хар толгод илрэл /ГХЭ/, Бор толгод /ГХЭ/ зэргийг ялгаад байна. Лити-Бериллийн хувьд: Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт Урт гозгорын илрэл -0.2%, /Li+Ta-Nb/ Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт Баян уул илрэл -0.2%, /Лити-Берилли/, Арван сар илрэл /Лити-Берилли/, Дөрвөн Дэрт илрэл. Литийн хувьд: Дорноговийн Өргөн сумын нутагт Өргөн илрэл лити-0.2%, Дундговийн Хулд Зос уул-0.3%, Дундговийн Дэлгэрцогт суиын нутагт Ногоолин илрэл лити-0.3%, /Никель-хром/, Бал чулууны хувьд: Сөрт /Бал чулуу/, Хөх Хад-1 Хөх Хад-2 Хэтийн төлөв нь одоогоор тогтоогоогүй боловч урт сунасан бүс ихтэй ихээхэн сонирхолтой талбайнууд тогтоогдсон бөгөөд үр дүнг товч хэлбэрээр дор сийрүүлэн бичлээ. Магнезит /магнезит+никель/ Сулинхээр /Никель-хром-магни/, Сайханы илрэл //TaNb-Li?/ Хээрийн ажлын явцад 147 эрдэсжсэн цэг, 40 орд, илрэл хэмээн өмнөх судлаачдын тодорхойлсон хэсгүүдэд шалгалтын маршрут	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									хийсэн бөгөөд үр дүнгийн хувьд зарим талбайг хэтийн төлөв багатай гэж үзсэн болно.	
		12	Үнэт, ховор, холимог, металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ хийнэ.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 39,325.1 2023 төсөв: 5,632.8 2023 гүйцэтгэл: 5,095.5	Үнэт, ховор, холимог, металлын чиглэлээр эрэл, үнэлгээний ажлын үргэлжүүлэх, хэтийн төлөвийн үнэлгээ хийнэ.	1. Меланж Сурвэй ХХК-ийн хэрэгжүүлж байгаа Эрэл үнэлгээ-2 төсөл Өмнөговь болон Дорноговь аймагт 4 хэсэг талбайд геологийн судалгааны ажлыг гүйцэтгэж, суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. Судалгааны ажлын товч үр дүн: Зараа талбай. Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдын нутаг: Зараа илрэлийн хэмжээнд 4 цооног өрөмдсөн. Өрөмдлөгийн үр дүнгээс харахад калишпатжсан хувирал бүхий зарим хэсэгтээ 0,5-1,0мм хүртэл зузаантай, кварц-кальцитын ан цав дагасан хялгасан судлуудын бүс (зузаан нь 70м хүртэл) агуулсан гранодиорит байна. Кернийн сорьцын химийн шинжилгээгээр Cu 0.001-0.02%, Zn 0.002-0.009%, байна. Гадарга дээр малтсан сувагт эдгээр бүс 1-5м, ховроор 9-10 м хүртэл зузаантай тогтоогдсон. Бусад хэсэг дээр бага зэргийн пиритжилт бүхий бүсүүд тогтоогдсон. Номт талбай. Дорноговь аймгийн Мандах сум: Номтын илрэлийн хэмжээнд кварц-турмалины судал агуулсан малахитжсан бүсүүдэд ховилон сорьцын шинжилгээгээр Cu 0.1-0.4%, цөөн сорьцод 1-9,85%, Zn 0.03-0.04%, Au 0,01-0,05гр/тн агуулга тогтоогдсон. Өрөмдлөгийн үр дүнд 0,5-1,0м хүртэл зузаантай бага зэрэг лимонитжсан, кварцжсан, малахитын түрхэц бүхий бүсүүд тогтоогдсон. Шинээр кварц-турмалины судлын бүс (өргөн 20-30м, урт 100м орчим) тогтоогдсон нь өрөмдлөгийн үр дүнгээр	90%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									цооногт ан цав дагасан пирит, ховроор халькопиритийн хялгасан судал /0,1см хүртэл зузаантай/ маягийн эрдэсжилтүүд агуулсан 2-6, заримдаа 10м хүртэл зузаантай, кварц, кварц-турмалины судал илэрсэн. Шинжилгээний үр дүнгээр зэс 0,1-0,7%, алт 0,1-0,85 г/тн хүртэл агуулга тогтоогдсон. Онгон тээг талбай: Өмнөговь аймгийн Мандал-овоо сум. Өмнөх судлаачдын ажлын үр дүнд цэглэн сорьцод зэс 0,007-0,5%, цөөн сорьцод 1% хүртэл, мөнгө 30-150 гр/тн хүртэл агуулга тогтоогдсон байдаг. Бүсийн хэмжээнд баганат өрөмдлөгийн 5 цооног өрөмдсөн. Лабораторийн үр дүнг боловсруулж тайланд тусгаж байна. Мандал талбай. Өмнөговь аймгийн Мандал-овоо сум.: Олон овоотын алтны хүдрийн бүсийн үргэлжлэл гэж үзэж болох энэ талбайд Эрлийн маршрут, геофизикийн соронзон, спектрометр, цахилгаан хайгуулын ажлын үр дүнгээр эрлийн 3 хэсэг ялган, тэдгээрт төвлөрүүлэн уул-өрөмдлөгийн ажил явуулж байна. Агуулагч карбонат-терриген хурдас, түүнийг зүссэн риолит-порфирын дайкуудын хил заагийг дагасан хувирлын бүсүүдээс авсан цэглэн болон ховилон сорьцын шинжилгээгээр Au 0,01-0,2 г/тн, цөөн сорьцод 2,3 гр/тн хүртэл агуулга тогтоогдсон байна. 4 талбайн фондын болон хэвлэгдсэн материалд холбогдох дүн шинжилгээг гүйцэтгэн, тухайн талбайд хийгдэх ажлын үндэслэл, аргачлалыг боловсруулж, ажлын хэмжээ, төсөл, төсвийг зохиож, ажлын	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									хөтөлбөрийг эрлийн талбай тус бүрээр нарийвчлан зохиосон. 1:200000, 1:50000 харьцлын геологийн зураглал, эрлийн ажил (нийт 7 тайлан) сэдэвчилсэн болон эрдэм шинжилгээний ажлын материалд тулгуурлан, геологийн, ашигт малтмалын, баримт материалын зургуудыг зохиосон. Геологийн анхан шатны баримт бүрдүүлэхэд хэрэглэгдэх, зохих стандарт шаардлага хангасан баримт бичиг, материалын бүрдлийг бүрэн хангасан. 2. Геосигналс ХХК-ийн хэрэгжүүлж буй Эрэл үнэлгээ-3 төсөл нь Дорнод аймгийн Дашбалбар, Чулуунхороот, Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт 2022 хээрийн үйлдвэрлэлийн ажил явагдсан. Бага уулын талбай: 1-р хүдрийн биет дээр: Хүдрийн биетийн зузаан 15-26 м-ийн хооронд 11 метр, дундаж агуулга Cu-1000 ppm, 2-р хүдрийн биет дээр 72-75 м-ийн хооронд 3 метрийн зузаантай Cu-3.043%, Mo-ны дундаж агуулга 1631ppm, Ag-20 ppm, 3-р хүдрийн биет 149-157 м хооронд 9 метрийн зузаан, дундаж агуулга Cu-1297ppm, 4-р хүдрийн биетэд 2 метрийн зузаантай Cu 0.3%, Mo-657 ppm. Элтүрүүтийн талбайгаас авсан цэглсэн сорьцонд хар тугалганы агуулга 1% хүртэл, As-1% хүртэл, 4 дээжинд алтны агуулга 0,01-2,37 г/тн агуулгууд гарсан. Мөн элтүрүүдийн талбайд малтсан 11-р сувгийн 64-72 м-ийн хооронд 9 м зузаан хүдэржсэн бүсэд хартугалганы агуулга 0,2174, мөнгө 11,4 г/тн, 9-23 м-ийн хооронд 15 м зузаан хүдэржсэн бүсэд хартугалга 0,1%, мөнгө 6 г/тн, мышьяк 0,2160% сурьма кларкаас өндөр гарсан.	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									Лутаагийн талбай нь төслийн талбайн төв хэсэгт байрлана. Энд хожуу юрийн Ямалх бүрдлийн гранитын массивын зүүн урагш 115 градусын чиглэлд сунасан томоохон 2 ширхэг судал болон паралель байрлалтай 2 жижиг судлаас тогтоно. Энд 574 м3 эзэлэхүүнтэй 5 суваг малтаж 49 ширхэг ховилон сорьц 65 ширхэг цэглсэн сорьц авсан. 170 метрийн гүнтэй 1 цооног өрөмдсөн ба 0,1-1,4 метрийн зузаантай 6 ширхэг кварцын судал огтолсон ба судлууд нь халькопирит, пирит, молибденитын шигтгээ болон судланцар хүдэржилттэй. Эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. “Геологийн судалгаа шинжилгээний төв”-ийн хэрэгжүүлж байгаа Эрэл үнэлгээ-4 төсөл нь Говь-Алтай аймгийн Шарга, Баян-уул сумдын нутагт орших судалгааны ажлын талбайн хүрээнд 2023 онд 1912 кв.км² талбайд сансрын зургийн тайлалт, 131.5 т.км эрлийн маршрут, 20 кв.км² 1: 10 000 масштабын эрэл, 12 кв.км² 1: 5 000 масштабын эрэл, 331.5 т.км эрэл- шалгалтын маршрут, 125 т.км авто маршрут, 983,2 шоо.метр суваг малталт, 4616,4 т.м кернт өрөмдлөг, 4364ш керн сорьц, 837ш ховилон дээж, 50ш анхдагч геохимийн дээж, 66ш шлихийн дээж, 100х25 метрийн торлолоор 7745ш хоёрдогч литогеохимийн сорьц, 270ш штуфын дээж, 370ш цэглэн дээж, 28ш протолоचेкийн дээж авах зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ. Мөн 30600км үйлдвэрлэлийн тээвэр, 14336 км хүн тээвэр, 18920 т.км ачаа тээвэрлэлтийн ажил хийсэн. Дээж, сорьцуудыг холбогдох лабораторийн шинжилгээнд хамруулсанаас өнөөдрийн байдлаар шинжилгээний ажил 74.1%-ийн гүйцэтгэлтэй	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									байна. Үүнээс тодорүүлбал 587ш цэглэн ба штуфын дээж, 5319ш литохимийн сорьц, 2856ш керний дээж, 806ш ховилон дээж, 10ш силикатын дээж, 20ш протолочек, 30ш шлих, 5ш аншлиф, 11ш петрографийн бичиглэл зэрэг судалгаа шинжилгээний үр дүнг аваад байгаа ба шинжилгээний ажил үргэлжилж байна. Мөн түүнчлэн 640ш дээжинд хувирлын эрдэс тодорхойлуулах шинжилгээг Магнетик сурвей ХХК-аар гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Өндөр богдын илрэлд хийсэн ажлын үр дүнгээр хэтийн төлөв гүний үргэлжилэл тааруу харагдаж байна. Ширдэгтийн илрэлд өрмийн 4 цооног өрөмдсөн үр дүнгээр алтны 5.5 хутийн агуулга байгаа нь илрэлийн хэмжээнд ажил үргэлжлүүлэн хийх шаардлагатай нь харагдаж байна. 2023 онд нийт 4616.3 т.м гүйцэтгэсэн Үүнээс Өндөрбогд талбайн Цахир толгой-1 буюу Суваг-6 илрэлд 3037.45т.м, Өндөрбогд алтны илрэлд 750тм, Холбоо толгой алтны илрэлд 443.25т.м, Конгломератын алтны илрэлд 150т.м; Ширдэгтийн талбайд 2 хэсэгт нийт 805.85т.м(4 цооног) өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэн. 3. Монполимет ХХК-ийн хэрэгжүүлсэн Баруун өмнөд монголын-Алт-2017 төслийн үр дүнгийн тайлан эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023.04.11-ний өдрийн хурлаар хамгаалагдсан. Аулын үр дүнгээр эрэл үнэлгээний ажил гүйцэтгэх эрлийн сонирхолтой 14 талбай ялгасан байдаг.	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									Хурлын тэмдэглэл, дүгнэлтийг УУХҮЯ-нд хүргүүлсэн. 5. “Магнетиксурвей” ХХК нь УУХҮЯ-ны 2022.06.10-ны өдрийн 2022/18 тоот геологийн даалгавар, ҮГА-тай байгуулсан 22/07 тоот гэрээний дагуу “Монгол орны алтны металлогенийн судалгаа” сэдэвчилсэн судалгааны хүрээнд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд алтны металлогенийн зураг зохиох ба Өмнөд Монголын алтны хэтийн төлвийн судалгаа”-г 45-р өргөргөөс урагш улсын хил хүртэлх 372,752.17 км.кв талбайд (Өмнөговь бүхэлдээ, Говь-Алтай, Баянхонгор, Дорноговь аймгуудын өмнөд хэсэг, Дундговь ба Өвөрхангай аймгийн зарим хэсэг хамарсан) гүйцэтгэсэн байна. - Замын амын талбайн алтны эрдэсжилт нь ороген шинжтэй, баян Au агуулгатай, нарийнхан 20-100 см зузаантай кварцын судлууд жижиг-дунд мөхлөгт гранодиорит тогтоогдсон. Au агуулсан кварцын судлууд нь хойш 15-25 градусын уналтай, 3Х 30°-аар хэвтээдүү байрлалтай кварцын судлуудыг хувиараа алт олборлогч нар 1-3 м хүртэл олборлосон байдалтай. Төв хэсэгт 100м орчим гүнтэй босоо ам (шурф) нэвтэрсэн байна. өргөрөгийн дагуу суналтай ойролцоогоор 5-400м орчим урттэй 40см хүртлэх өргөнтэй олон тооны алтны агуулга /Au 0.13-95.7 гр.тн/.агуулсан кварцын судлуудтай. - Шар ухаа илрэлийн талбайд судлууд нь ганц нэгээр байхаас гадна заримдаа хэд	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									хэдэн зэрэгцээ судлууд бүс үүсгэсэн байдаг. Гэрлийн болон шинжилгээгээр Au-0.09-0.12г/т , W-0.05-0.7%, Zn-0.03%, Mn-0.007%, Fe-0.01-50.2% агуулга тогтоогдсон. Элгэн хадны алтны илрэл нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт, Баруун хар толгойн худгаас эгц хойш 0.7 км зайд, Мөрөгцөгийн худгаас зүүн урагш 150м-иар 4.4 км-т тархсан кварц-сульфидын судал, хувирлын бүсэд алт 0.01-1.26 г/т , зэс 0,005-0,018%, молибден 0,001- 0,01%, Ag-1-6 г/т, As-0,005-0,15%, Pb-0,01-0,05%, Fe-3%, Sb-007%, агуулгатай байна	
Дундаж үнэлгээ:										91,67%

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:
Дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан
мэргэжилтэн Б.Мөнхтуяа
Холбоо барих утас: 70181208
Цахим шуудан: b.munkhtuya@ngs.gov.mn